

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 16

- Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./*
- 1.

5 – 16

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 07 дугаар сарын 03-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Б.Жаргалан, М.Мандхай, О.Цогтгэрэл.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Э.Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү, Монголбанкны Банкны бодлогын хэлтсийн захирал Л. Эвшинхорлоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Нэг.Монголбанкны тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төсөл**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Монголбанкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Хоёр.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Байнгын хорооны дарга Р.Сэддоржийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

**Гурав.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Лувсанжамц нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 32 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн бидний өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, П.Батчимэг, Э.Батшугар, Х.Ганхуяг, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, Б.Найдалаа, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг нарын Их Хурлын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 68.0 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 07 сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 06 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Э.Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Б.Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Э.Мөнхнасан Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Ө.Мөнх-Ундарга Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал, Г.Борхүү Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал, Л. Эвшинхорлоо Монголбанкны Банкны бодлогын хэлтсийн захирал.

Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төсөл тус бүрийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Нэг.Монголбанкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Х.Ганхуяг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг.

Х.Ганхуяг: Банкны хуульд орж байгаа өөрчлөлт маань эргээд нөгөө Өрийн удирдлагын хууль ч байдаг юм уу, тэр хуулиудад ямар нэгэн нөлөөлөл байхгүй биз дээ. Тийм ээ? Энэ дээр тодруулмаар байна.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгч нь хаачсан юм? Яагаад ирээгүй юм?

Энэ дээр Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч, Т.Жамбаажамц хоёроос л нэг асуулт байгаад байгаа юм л даа. Хууль байхгүй юм уу?

Уг нь Эдийн засгийн байнгын хороонд харьяалагддаг л хоёр байгууллага даа. Тэгээд холбогдох хуулийг нь хэлэлцэж байхад ч орж ирэхээ болиод, өмнө нь ч бас орж ирэхгүй л байгаад байх шиг байсан. Энэ дээр ер нь болохгүй бол арга хэмжээний асуудал ярих ёстой юм биш үү. Байнгын хорооны дарга аа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд.

Л.Соронзонболд: Төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Зүгээр энэ дээр Монголбанкнаас нэг асуулт байгаа юм. Энэ хуулийн өөрчлөлт орсноороо арилжааны банкнуудаас хувийн секторт олгодог зээлийн хэмжээ хэдий хэмжээгээр буурах вэ? Өөрөөр хэлбэл CROWDING OUT¹ гээд эффект гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Тэр хэмжээг ер нь тооцсон уу?

Нийслэл мэдээж ирэх 4 жилийн хугацаанд иймэрхүү бонд гаргана гээд тооцоолсон байгаа байх.

Тэгэхээр тэр хэмжээгээр хувийн секторт очиж байгаа зээлийн хэмжээ буурна гэдэг дээр ямар нэгэн тооцоо хийсэн юм байна уу?

Р.Сэддорж: Хариулт. Гараа өргөөрэй. Ажлын хэсэг 3 номер.

Г.Борхүү: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Нийслэлийн бондын 17.4 дэх заалтад оруулснаараа болохоор мэдээж яг тэр оруулсан хэмжээгээрээ хувийн секторт олгох боломжтой байгаа зээлийн дүн буурна. Яг заалтын томъёололтой холбоотой хэсэг дээр бид дөнгөж сая танилцаж байгаа учраас яг нарийвчилсан тоонуудыг маш яаралтай хугацаанд нь тооцоолоод эргээд Та бүхэнд танилцуулъя.

Ямар ч байсан “Нийслэл” бондын хувьд зохистой харьцааны хувьд бид Монголбанкны зүгээс Засгийн газрын үнэт цаастай дүйцэх хэмжээ буюу эрсдэлийн жинг 20 хувиар жигнэх заалтуудыг оруулсан байгаа.

Дээрээс нь Монголбанкны хүлээн зөвшөөрөгдөх барьцаа хөрөнгийн жагсаалтад бас нийслэл бондыг хүлээн зөвшөөрөхөөр оруулсан ийм хөнгөлөлттэй нөхцөлүүд одоогоор хэрэгжиж байгаа.

Үүн дээр нэмээд энэ хуулийн заалт дээр Засгийн газар болон Төв банкны үнэт цаастай дүйцүүлэх хэмжээгээр 17.4 дээр оруулах юм бол бас. Хэрвээ банкууд энэ хэмжээгээр худалдаж аваад үнэт цаасны портфелийг нэмэгдүүлнэ гэх юм бол тэр хэмжээгээр хувийн сектор болон иргэдэд олгох зээлийн хэмжээ бас буурна гэж байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн тодруулж асууна.

Л.Соронзонболд: Яах вэ, өнөөдрийн байдлаар Засгийн газрын бондын хэмжээ их бага байгаа учраас арилжааны банкууд нийслэлийн бондыг сонирхож хөрөнгө оруулалт хийх байх л даа.

¹ Төрийн хөрөнгө оруулалт, төсвийн бодлого нь хувийн секторын идэвхийг бууруулах сөрөг нөлөө үзүүлдэг үзэгдэл.

Тэгэхдээ гол нь энэ дээр нэг анхаарах зүйл нь бас их хэмжээтэй болов уу л гэдэг дээр жоохон бодолцох ёстой байх.

Тийм учраас Монголбанк энэ дээр анхаарах ёстой л гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: 5 номер. Х.Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Л.Соронзонболд гишүүний асуултад би нэмээд хариулахад орон нутаг бонд гаргах зөвшөөрлөө заавал Их Хурал, Засгийн газраас авна шүү дээ.

Бид өөрөөр хэлбэл тийм хязгааргүй хэмжээнд бонд гаргах тийм зохицуулалт байхгүй. Өрийн удирдлагын тухай хуулиа барина гэж нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, ерөөсөө энэ оруулж байгаа өөрчлөлтийн гол онцлог бол Засгийн газрын үнэт цаастай адилтгах хэмжээгээр бид дотоодын зах зээл дээр орон нутаг бондоо гаргадаг болъё гэдэг л ийм өөрчлөлт орж байгаа.

Түүнээс хязгаарын хувьд заавал Засгийн газар, Их Хурлаар дотоод бонд гаргах өрийн дээд хязгаараа Өрийн удирдлагын тухай хуульдаа захирагдаж бид нар явагдана гэдэг энэ зарчмаа л хэлье.

Р.Сэддорж: Монголбанкнаас нэмж хариулах уу?

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн нь байна уу? Алга байна.

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Дараагийн хуулийн төсөл.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Асуулт гарсангүй. Санал ирээгүй байна.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Асуулт алга байна. Санал гаргасан гишүүн алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Асуулт алга байна. Санал гаргасан гишүүн алга байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу.

Асуулт алга байна. Санал гаргасан гишүүн Алга байна.

Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг.

Х.Нямбаатар даргаас асууя даа. Өчигдөр гишүүд асуугаад байсан. Тэрийг та нэг тайлбарлаадхаач. Таксины жолооч нарыг ямар журмаар, ямар бодлогоор тэр санхүүжилтийг олгох гээд байна вэ гэдэг дээр гишүүд нэлээн юм асууж байна лээ.

Үүнийг та дэлгэрэнгүй тайлбарлаад өгөөч. 5 номер.

Х.Нямбаатар: Миний бие Нийслэлийн Засаг даргаар томилогдоод одоо яг 1 жил 8 сар болж байна.

Тэгээд очоод бидний хамгийн эхний хийсэн ажил “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан” гэдэг санг байгуулсан. Одоогийн 1 жил 8 сарын хугацаанд “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-д ойролцоогоор 40 гаруй тэрбум төгрөг цуглараад байгаа.

Нийтийн тээврийг хөгжүүлэх сан өмнө нь ерөөсөө огт ажиллаж байгаагүй.

Засгийн газраас “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-д төвлөрүүлээрэй гэсэн утгатай 400 автобус авч өгсөн. Тэр мөнгө буцаж эргэн төлөгдөөгүй. Тэгвэл бид сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар хотод худалдан авсан бүх автобусуудаас эргэн төлөлтийг нь тодорхой хүүгийн хамт эргэн төлүүлж, нийтийн тээврийг хөгжүүлэх сан бүрдүүлээд явж байгаа.

Одоо Улаанбаатар хотод энэ жил 45 автобус шинэчлэх юм бол ойрын төсөвтөө бид автобусны парк шинэчлэлтээр санаа зоволтгүйгээр “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-гаа арвитгаад явах юм.

Үүнтэй зэрэгцээд Улаанбаатар хотод нэг дутагдаж байгаа нийтийн тээврийн төрөл үйлчилгээ бол стандартын таксины үйлчилгээ. Өөрөөр хэлбэл симпорттой, таксиметртэй таксины үйлчилгээ, 2000-аад оны үед байсан шар таксинаас хойш үндсэндээ албан ёсны таксины бүрэн үйлчилгээгээ үзүүлэх чадамжгүй болсон.

Тэгэхээр бид тусгай зөвшөөрөлтэй, байгаль орчинд ээлтэй 100 хувь цахилгаан таксины үйлчилгээ үзүүлэх сонирхолтой аж ахуйн нэгж байгууллагуудын дунд нээлттэй тендер зарлах замаар “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-гаас таксины үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудад тодорхой зах зээлийн жишиг өртгөөс бага хүүтэй мөнгө зээлүүлэх замаар энэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг Улаанбаатар хотод нэвтрүүлэх гэдэг бодлого барьж ажиллаж байгаа.

Мөн цаашлаад Улаанбаатар хотын томоохон зочид буудлуудын орчимд LONDON CAB маягийн таксины бас зарим төрөл, үйлчилгээг нэвтрүүлэх гэсэн ийм төлөвлөгөө гараад, үүнийхээ дагуу “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-д байгаа мөнгийг хүүтэй нөхцөлөөр нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар таксины үйлчилгээг нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хуулиар нээе гэж байгаа юм.

Бид 2023 оны 12 сард хууль батлуулахдаа “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-гийн мөнгийг зөвхөн “автобусан”-д зориулна гээд бичсэн байсан. Гэтэл автобусны маань хэрэгцээ хангагдсан учраас “автобус” гэдгийн араас таслал тавиад “такси” гэж оруулж ирж байгаа юм.

Түүнээс хувь хүнд өгөх тухай ойлголт байхгүй. Энэ таксины паркийн баазын зохион байгуулалтад орсон, тэгээд хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангасан стандарт үйлчилгээг нэвтрүүлэх гэж байгаа юм.

Цагдаагийн ерөнхий газраас сүүлийн жилүүдэд гарсан гэмт хэрэг, зөрчлүүд дээр нэлээн ноцтой мэдээ мэдээллүүд байгаа. Сүүлийн үед хувиараа такси үйлчилгээ үзүүлж байгаа энэ төрөл хэлбэрүүдээс болж охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, дээрэмдүүлсэн, бусад гэмт хэргийн золиос болсон тохиолдлууд нэлээдгүй байгаа учраас их хотын стандартын дагуу стандартын таксины үйлчилгээг л бий болгох зорилго тавьж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Одоо энэ чинь бусад улсууд, хотуудад нэг өнгийн байдаг. Такси нь. Тийм ээ. Манай хотод тийм юм байгаа юу? Байхгүй. Тийм ээ.

Үүнийг хэзээ яг ийм стандартад оруулах вэ? Энэ мөнгө тэр лүү чиглэнэ гэсэн үг үү? 5 номер.

Х.Нямбаатар: Уг нь манай хотын стандартаар ийм байгаа юм. Нийтийн тээврийн автобус нь улаан өнгөтэй байна, такси нь шар өнгөтэй байна гээд хотын стандартаа баталсан.

Тэгээд такси үйлчилгээнд одоо явж байгаа 5 аж ахуйн нэгж 246 такситай байгаа. Тэгээд бараг бүгд өөр өөр өнгийн, дандаа 10-аас дээш жилийн насжилттай таксины үйлчилгээ явж байгаа.

Бид нарын 2023 оны 12 сард хийсэн судалгаагаар Улаанбаатар хотод такси үйлчилгээ эрхлэхэд хамгийн багадаа 5 мянгаас дээш тооны такси үйлчилгээний стандартын шаардлага хангасан автомашинууд үйлчилгээ хэрэгжүүлэхэд хангалттай байна. Үүний хажуугаар зэрэгцээд нөгөө “UBCab” гээд одоо “Uber”-тэй адилхан үйлчилгээ үзүүлдэг хүмүүс бас зэрэгцэж энэ үйлчилгээг үзүүлэх боломжтой юм гэдэг ийм судалгаануудыг гаргасан.

Тэгэхээр бид яг хотын стандартын дагуу нэгдсэн өнгийн, нэгдсэн... /минут дуусав/

Р.Сэддорж: Хуучин явж байгаа таксины өнгийг нь өөрчлөхгүйгээр шинэ такси ярьж байгаа юу? Тийм ээ. Хувь хүмүүс таксид орж болохгүй гэсэн үг үү? Өөрийнхөө машинаар.

Хувь хүмүүс энэ дээр оролцох гол сонирхолтой байдаг юм билээ шүү дээ. Бид нарыг нэг өнгөтэй болгоод өгөөч. Хүн харахад такси гэдэг ойлгомжтой болгоод өгөөч л гэсэн ийм хүсэлтүүд л байдаг юм билээ.

Энэ дээр та бүхэн гаргалгаа, сайн тайлбарлаж өгөхгүй бол болохгүй байх гэж бодож байна.

17.6 дээр энэ хуулийн 17.1-д заасан авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг Нийслэлийн Засаг даргад шилжүүлж болно, шилжүүлнэ гэж байна.

Тэгэхээр тээврийн хяналтыг аль хэсгийг нь Нийслэлийн Засаг даргад, аль хэсгийг нь Зам, тээврийн яаманд байгаа юм бэ байлгах юм бэ? Үүнийгээ яг тодорхой хэлж өгөөч гээд гишүүд бас ийм санал гаргаад байна. 5 номер. Х.Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Улсын үзлэгийг л ярьж байгаа юм л даа.

Улаанбаатар хотын харьяалалтай, бүртгэлтэй үзлэг оношилгоонууддаа хяналт тавьдаг, зөвшөөрөл олгодог тогтолцоо нь хот дээрээ шилжиж ирье. Хөдөө орон нутгийн улсын үзлэг оношилгоо нь хөдөө орон нутагтаа харьяалагдъя. Автотээврийн үндэсний төвдөө харьяалагдъя гэж байгаа.

Одоо сүүлийн үед ийм ноцтой зөрчлүүд байгаа нь хайбрид буюу приус маягийн автомашины нүүрсний янданг хууль бусаар гадаадад маш их хэмжээгээр экспортолсон. Улсын үзлэгт орохын өмнө үзлэгийн гадна талын талбай дээр 50-иас 100 мянган төгрөгөөр жинхэнэ нүүрсэн янданг угсарч өгөөд үзлэгт оруулаад гаргаж ирээд тайлж авдаг ийм үйлчилгээнүүд явагдаад байгаа юм.

Тэгээд энэ жил би Зам, тээврийн сайдад албан бичиг хүргүүлээд нөгөө нүүрсэн яндан дээр нь арлын дугаарыг нь төмрөөр ингээд цифрийг нь цохиулж байгаа. Тэгж байж энэ зөрчлүүд харьцангуйгаар багасаж байгаа.

Дээр нь улсын үзлэг тойрсон авлига, ашиг сонирхлын зөрчилтэй дүгнэлт бичиж өгдөг, үзлэгт оруулалгүйгээр үзлэгийн шаардлага хангахгүй тээврийн хэрэгслүүдэд үзлэгт орсон гэдэг дүгнэлт гаргаж өгдөг зөрчлүүдийг арилгах үүднээс Нийслэлийн Авто тээврийн бүртгэлийн төвийн дэргэд үзлэг, оношилгооны тусгай зөвшөөрөл болон хяналтыг хариуцуулъя л гэдэг зүйл ярьж байгаа.

Энэ нь зөвхөн Улаанбаатар хотын автомашинд харьяалалттай. Тийм.

Р.Сэддорж: Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Дараагийн хуулийн төсөл.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Асуулт байхгүй байна. Санал гаргасан гишүүн алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

Асуулт алга байна. Санал гаргасан гишүүн алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу?

С.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Уг нь Санхүүгийн зохицуулах хорооны дарга байхгүй учраас асууж чадахгүй байна.

Яг энэ хуулийн төсөл гэхээсээ илүүтэй хууль хэрэгжилтийг зохион байгуулах асуудал байгаа юм. Өнөөдөр даатгалын компаниудын гапк-ийг хэрэглэгчдэдээ ээлтэй буюу тэр даатгалын гэрээний буюу хэрэглэгчийн гэрээгээ хэрхэн биелүүлж байгаагаар нь үнэлж олон нийтэд зарладаг болмоор байна.

Нөхөн олговрыг олгож байгаа хэмжээ, тэрийг шийдэж байгаа цаг хугацааны хэмнэлт, эргээд хэрэглэгчдэд гэрээний хатуу стандарт тулгадаггүй зэрэг байдлаар нь хэрэглэгчид ээлтэй байдлаар нь даатгалын компаниуд гапк-ийг тогтооно уу гэхээс биш том жижиг хэчнээн даатгал цуглуулсан гэдгээр нь биш.

Тэгэхээр энэ соёлыг ойлгомжтой болгож, эндээс хэрэглэгч өөрөө зөв сонголт хийх бололцоог Санхүүгийн зохицуулах хороо гаргаж өгмөөр байна.

Тэгээд маш олон даатгалын компаниуд байдаг. Яг цагаа тулахаараа даатгалын нөхөн олговор олгох асуудал дээр дандаа гар татдаг, элдэв янзын шалтаг хэлдэг. Тэгээд ерөөсөө гэрээний нөхцөл дээр хэлэлцээр хийдэггүй учраас яг стандарт гэрээний нөхцөлөө зурдаг. Тэгээд маш олон зүйлүүд дээр даатгалын тохиолдлуудыг үгүйсгэдэг ийм зүйлүүд байгаа юм.

Тийм учраас Санхүүгийн зохицуулах хороо арга барилаа жоохон өөрчлөөд, ялангуяа энэ хэрэглэгчийн гэрээ буюу даатгалын харилцаан дээр, даатгалын компаниудын rank-ийг тогтоох аргачлалаа шинэчлээд зарлаач ээ. Хэрэглэгчдэд ээлтэй байдлаар зарлаач ээ гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Тэгээд юм болгоныг хэдүүлээ жоохон арга барил, хандлагаа өөрчлөхгүй бол ингэж явж ирсэн юм гэдэг байдлаар яваад байж болохгүй байна.

Тийм учраас Санхүүгийн зохицуулах хороо энэ асуудлыг сонсож байгаа байлгүй дээ.

Эдийн засгийн байнгын хорооны хуралд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нар ирэхээ болилоо. Үүнийг бүр нэг анхаараач ээ гэдэг зүйлийг хэлмээр байна.

Р.Сэддорж: Г.Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Хотын даргаас асуух гэсэн юм.

Осол гарчхаад даатгалын компани нь цагдаа ирэхийг хүлээгээд дунджаар 40 минут зогсдог гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Тэрийг л цахимаар шийддэг болъё гэсэн ийм зохицуулалт.

Үүнийг хийснээр түгжрэл хэдэн хувиар буурах нөлөөлөл байгаа вэ? Ийм ухаалаг Улаанбаатар гэсэн бодитоор хэрэгжих гээд хуулийн төсөл оруулж ирж байгаад их баяртай байна. Тэгээд ослоос шалтгаалсан түгжрэл хэдэн хувиар буурах боломжтой бол гэсэн бодитой судалгаа байгаа болов уу?

Р.Сэддорж: 5 номер. Х.Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Би Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Энэ Жолоочийн хариуцлагын тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн хамгийн гол үндсэн агуулга бол ерөөсөө яг таны саяын ярьдаг. Өөрөөр хэлбэл зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд гэмтсэн тохиолдолд цагдаагийн дуудлагын бүрэлдэхүүн ирж газар дээр нь хэргийн газрын үзлэг хийгээд, араас нь даатгалын компани ирж дүгнэлтээ гаргаад явах хооронд нэг ослын дуудлага дээр ойролцоогоор 40 минут тухайн тэр эгнээг түгждэг гэдэг дундаж судалгаа байдаг.

Өчигдөр би танд жишээлбэл Улаанбаатар хотод гарсан юуны талаар товчхон мэдээлэл хүргэе. Бид хиймэл оюун ухаан бүхий камерын системийг ашиглалтад оруулснаас хойш яг бодит цаг хугацаагаар Улаанбаатар хотод өдөртөө хэдэн машин орж байгааг тоолоод, үүнээс ямар ямар зөрчилтэй, хэдэн зөрчил гаргасныг тоолж байгаа.

07 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотын замын хөдөлгөөн нийтдээ 554 мянга 043 машин. Өөрөөр хэлбэл 554 мянган машин хөдөлгөөнд оролцсон байна.

Эдгээр хөдөлгөөнд оролцсон машинуудын:

- 44 мянга 490 нь хөдөө орон нутгийн машинууд байна.
- 22 мянга 696 нь татвараа огт төлөөгүй машинууд байна.
- Техникийн үзлэгт ороогүй 10 мянга 309 машин байна.

Нэг өдрийнх шүү дээ. Дандаа. Энэ 07 сарын 01-ний өдөр.

Жолоочийн хариуцлагын даатгалын албан журмын даатгалд хамрагдаагүй 22 мянга 797 машин.

Өөрөөр хэлбэл татвар, даатгал хоёрын тоо бараг ойролцоо гарч байгаа.

➤ 100 мянган төгрөгөөс дээш торгууль төлөөгүй 5600 машин өчигдөр хөдөлгөөнд оролцсон байна.

➤ Илрүүлсэн зөрчил гэвэл 458 мянган зөрчил илэрч байгаа юм.

Өөрөөр хэлбэл 458 мянган зөрчлийн маань тодорхой хувь нь осол боллоо гэж үзэхээр түүнийг тухайн зам дээр 30-аас 40 минутаар үржүүлэхээр таны асууж байгаа нөгөө тоо болж гарч ирэхээр байгаа.

Тийм учраас хоёр машин хоорондоо шүргэлцлээ гэж үзэхэд шууд хоорондоо тохиролцоод замын камерын нэгдсэн хяналтын систем дээр хэдүүлээ нотлох баримтаа цуглуулаад даатгалын компаниар асуудлаа шийдүүлье гээд л шууд газар дээрээ хөдөлж явъя гэж байгаа юм.

Хүний амь нас, эрүүл мэнд гэмтсэн тохиолдолд заавал цагдаагийн бүрэлдэхүүн ирнэ. Бусад тохиолдолд нь шууд хөдлөөд явна. Хөдлөхдөө тухайн тэр дэд төвийн хяналтын камерын тэр хэсэгт өртсөн хэсгээр нь нотлох баримт, цаг хугацаа, тэр улаан, цагаан шугам давсан зэрэг энэ тэрийг нь тодорхойлдог энэ систем рүү бүрэн шилжиж байгаа.

Ингэснээр нөгөө 30 минут, 40 минут заавал даатгалын компани, цагдаагийн бүрэлдэхүүн ирэхийг хүлээлгүй явдаг энэ зарчим руу шилжиж байгаа.

Р.Сэддорж: Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Одоо Монголбанкны Ерөнхийлөгч Төрийн байгуулалтын байнгын хороон дээр давхар яг энэ асуудал хэлэлцэгдээд байгаа учраас тэнд асуултад хариулж байсан юм байна.

Сая Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Л.Соронзонболд, П.Сайнзориг нарын гишүүд Монголбанкнаас асуулт асуух гэсэн боловч таныг байхгүй байна гэж нэлээн хэдэн асуулт асуусан.

Танай улсууд танд хэлсэн байлгүй. Энэ дээр хариулт авъя. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Сайн байцгаана уу? Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Сая Ерөнхий сайд дээр бас дуудагдаад, тэндээс шууд наашаа хүрээд ирсэн.

Тэгэхээр ямар асуулт асууж байгааг сая яасангүй. Тэгэхдээ яах вэ өнөөдрийн орж байгаа, хэлэлцэж байгаа асуулттай холбогдуулаад танилцуулга дотор Улаанбаатар хотын гаргаж байгаа бондын эрсдэлийн жингийн талаар л асуудал байгаа.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад “тэг” хувийн эрсдэлийн жингээр үнэлэгддэг 2 үнэт цаас байдаг.

► **Нэг дэх нь,** Засгийн газрын бонд “тэг” хувиар эрсдэл нь.

► **Хоёр дахь нь,** Төв банкны үнэт цаас “тэг” хувиар эрсдэл нь үнэлэгдэж явж байгаа.

Өмнө нь Улаанбаатар хот бас бонд гаргасан байгаа. Орон сууцжуулалттай холбоотой. Тэр бондын эрсдэлийн санг 20 хувиар үнэлээд явж байгаа.

Арилжааны банкнуудын гаргасан үнэт цаас, бондууд, хувийн аж ахуйн нэгжүүдийн гаргасан бондууд 100 хувиар эрсдэлийн сан нь үнэлэгдэж явдаг.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт дээр Улаанбаатар хотын бондыг “тэг” хувь болгож болох уу гэдэг асуудал одоо энэ хуулийн зохицуулалтад орж ирж байгаа юм билээ.

Тэгэхээр өнөөдөр угаасаа 20 хувиар буюу хувийн сектороос хамаагүй хөнгөлөлттэй эрсдэл нь үнэлж байгаа учраас одоо яг хууль дээр ийм заалт орох шаардлага байна уу л гэдэг ийм л байр суурь бас байгаа л даа. Монголбанканд.

Р.Сэддорж: Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн О.Цогтгэрэл танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархлаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хуралдаан 29 минут үргэлжилж, 13 цаг 01 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД